

СҮХБААТАР АЙМГИЙН ЖААХАН ШАРГА ТЕАТР



**СҮХБААТАР АЙМГИЙН ЖААХАН ШАРГА
ТЕАТРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГУРАВДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2024 он

**ЖААХАН ШАРГА ТЕАТРЫН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Дотоод товъёо

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, УДИРДЛАГА, САНХҮҮ

1.1 Хөгжимт Жүжгийн Театрын үндсэн нэгжийн бүтэц, санхүү

ХОЁР. СОЁЛ ГЭГЭЭРЭЛ, УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2.1 Төлөвлөгөөт уран бүтээл

2.1.1 Жүжиг

2.1.2 Концерт

2.2 Төлөвлөгөөт бус уран бүтээл

2.2.1 Жүжиг

2.2.2 Концерт

2.2.3 Уралдаан тэмцээн /өөрийн зохион байгуулсан/

2.3 Олон улс, улс, бүст зохион байгуулагдсан наадам, фестиваль, үзэсгэлэн, уралдаан, тайлан тоглолт, түүнд оролцсон байдал

ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦ, СОЁЛЫН ӨВИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАЛТ /Хувь хүний хөгжил, мэргэжил дээшлүүлэлт/

3.1 Сургалт

3.1.1 Мэргэшүүлэх сургалт /Их, дээд сургуульд гэрээгээр болон бие даан өөрийгөө хөгжүүлэх сургалт/

3.1.2 Хүний нөөцийн төлөвлөлт /Ирээдүйн мэргэжилтэн бэлтгэх сургалт/

ДӨРӨВ: СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, ГАДААД ДОТООД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1 Гадаадын байгууллагатай байгуулсан хамтын ажиллагаа

4.2 Дотоодын байгууллагатай байгуулсан хамтын ажиллагаа

ТАВ: БУСАД

ЖААХАН ШАРГА ТЕАТРЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, УДИРДЛАГА, САНХҮҮ

1.1 Жаахан шарга театрын үндсэн нэгжийн бүтэц, санхүү */нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн тэнхим, нэгжийн нэр, удирдлага/*

Жаахан шарга театр нь Дорнод монголын ард түмний ёс, зан заншлын дэвтагдашгүй онцлогийг орчин үеийн дэвшилтэт ололтоор баяжуулан хөгжүүлсэн, Монголын соёл урлагийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц уран бүтээлээр үзэгчдэд үйлчилэхэд оршин байна.

Жаахан шарга театр нь 2024 оны 09 сарын байдлаар даргын дэргэдэх 2 зөвлөл, 3 нэгж, 4 уран бүтээл ангитай, нийт 79 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс:

- Үндсэн ажилтан – 70 /88,6%/
- Дагалдан – 2 /2,5%/
- Туршилтаар – 1 /1,2%/
- Гэрээт – 6 /7,5%/
- Ажилд орохыг хүссэн 4 иргэнийг Уран сайхны зөвлөл, Захиргааны зөвлөлийн ур чадварын шалгалт, ажлын ярилцлаганд оруулж, үүнээс 2 ажилтныг ажлын байраар хангаад байна. Үүнд: Зураач-1, эмэгтэй жүжигчин-1. Чөлөөлөгдсөн-1.
- Сул ажлын байр: Тайзны туслах, жолоочийн сул орон тооны ажлын байрны нээлттэй зарыг байршуулаад байна.
- Шагнал урамшуулал: Соёлын ажилтны өдрөөр 2 ажилтан МУ-ын ЗГ-ын шагналаар, 1 ажилтан ТББ-ын шагналаар шагнуулсан.
- Театрт нэн шаардлагатай байгаа Ёочин хөгжимчин бэлтгэх зорилгоор 9 сарын 02-ноос эхлэн 12-р ангийн 1 сурагчийг МУК-ын Ардын хөгжмийн тэнхмийн эрхлэгч, ёочин хөгжимчин МУСТА Б.Байгалмаа багштай гэрээ хийж сургаж эхлээд байна.

Ажилтан албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах чиглэлээр мэргэжлийн багш нар, нэгжийн дарга нар, үйлчлэгч, оффисын ажилтнууд, угтах хэсэгт үзэгчдийн амрах сандал зэрэг 5 нэр төрлийн 17 ширхэг тавилгыг шинээр авсан. Үүнд нийт 9200,0 мян.төг-ийг зарцуулсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар "Жаахан шарга театрын зөөврийн тоног төхөөрөмж худалдан авах тендер"-ээр шалгарсан "Электрон техник" ХХК-аас 75660.0 мян.төг-ийн дууны тоног төхөөрөмжүүд хүлээн авч, орлогод бүртгэн авлаа.

Тус театр нь 2024 оны 09 сарын 20-ны байдлаар улсын төсвөөс 1711515.3 мян.төг орон нутгийн төсвөөс 181181.5 санхүүжилт авч үндсэн цалин 1340884.4, НДШ 140792.7 мян.төгрөг, уран бүтээлийн зардалд 24330.0 мян.төг, тогтмол зардал 179821.9 мян.төг Хангамж бараа материалын зардал 18448.6, бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХураамж 24330.0 мян.төг, Томилолтын зардал 1500.0 мян.төг, 5 жилийн тэтгэмж /2хүнд/ 15276.0 мян.төг, зарцуулсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 72705.0 мян.төгрөг төвлөрүүлж Хангамж бараа материалын зардал 6791.6, бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХураамж 8703.0 мян.төг, томилолтын зардал 27215.4 мян.төг, урсгал засвар тавилга 15010.2 нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, урамшуулал 2470.0 мян.төг, зарцуулж ажиллалаа.

Жаахан шарга театр нь 2024 оны 09 сарын байдлаар 26 үзвэр үйлчилгээ зохион байгуулж, 11566 хүнд үйлчилснээс, урлагийн тоглолт 2623, бусад үйл ажиллагаанд 3561 хүн хамрагдсаж, хөгжлийн бэрхшээлтэй 66 иргэн, 5316 хүүхдэд үйлчилжээ.

ХОЁР. СОЁЛ ГЭГЭЭРЭЛ, УРЛАГ, УРАН БҮТЭЭЛ

/Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус уран бүтээл/

Театрын бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж, Байгууллагын урын санг шинэ, шилдэг бүтээлээр баяжуулах, маркетингийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, байгууллагын өдөр тутмын удирдан манлайлалаар хангаж, албан хаагчдыг үнэлэн дүгнэх, хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төсөв санхүүг үр ашигтай зарцуулах хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэх зорилтыг хэрэгжүүлж ажилласан. Үүнд дараах ажил үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.

2.1. Төлөвлөгөөт уран бүтээл

Жүжиг

1. МУСТА У.Эрдэнэбаярын найруулга "Ромео үхэх ёсгүй" хүүхдийн оролцоот жүжгийн ахлах ангийнханд тоглож 136 хүүхдэд үзүүлсэн. Нийт зардал 3000.0 мян.төг-ийг зарцуулсан.

2. "Жаахан шарга" театрын Ерөнхий найруулагч У.Эрдэнэбаяр Марша Норманы "Тавтай нойрсоорой ээж ээ!" зохиолоос сэдэвлэсэн "Чөлөөлөлт" пластик жүжгийг Соёлын бүтээлч сараар /11 сард/ үзэгчдийн хүртээл болгохоор бэлтгэл ажилдаа ороод байна.

3. МУГЗ Л.Гомбосүрэнгийн найруулгаар С.Михалковын “Бардам туулай” хүүхдийн жүжгийг 10 сард театрын Уран сайхны зөвлөлд хүлээлгэж өгөхөөр жүжгийн бэлтгэл ажил явагдаж байна.

Концерт, бусад арга хэмжээ

1. Цагаан сарын баярт зориулан МУСТА У.Эрдэнэбаярын зохиол, найруулга “Дэм дэмэндээ” теле контентыг BBS телевизтэй хамтран гаргаж давхардсан тоогоор 18 мянган хүн үзсэн.

2. Жаахан шарга театр болон Очирдүүрэн хийдийн хамтарсан Хилэнт эх хэмээх модон луу жилийн Шашин урлагийн цэнгүүн шинийн 15 буюу 2024 оны 02-р сарын 24-нд зохион байгууллаа. Нийт 286 үзэгч сүсэгтэн олонд хүргэсэн.

3. Олон улсын эмэгтэйчүүдийн баярын МУСТА 3.Далайгийн найруулга “Домгийн хатираа” этик концертыг тоглож нийт 483 үзэгчид хүргэсэн.

4. 3 сарын 27-31-ний хооронд МУСТА 3.Далайгийн найруулга “Домгийн хатираа” этник концерт, МУСТА Б.Мөнхжаргалын хөгжим, МУСТА 3.Далайгийн найруулга “Мжжрын байшин” мюзиклыг Багануур дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь аймаг болон Замын-Үүд сумдад аялан тоглолт тоглосон.

5. Дэлхийн бүжигчдийн өдрийг тохиолдуулан БҮЖИГ ангийн “THE WORLD OF DANCE” бүжгийн тайлант өдөрлөгийн 4 сарын 29-нд амжилттай зохион байгуулж нийт 220 үзэгчид хүргэсэн.

6. Бүх нийтийн соёл, урлагийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд “Жаахан шарга” театр нь Гэгээн муза-11 наадмын шилдэг бүтээл "Муурын байшин" мюзикл, МУСТА 3.Далайгийн найруулга "Домгийн хатираа" этник концерт 5 сарын 27-нд Асгат, 5 сарын 28-нд Эрдэнэцагаан, 5 сарын 29-нд Дарьганга, 5 сарын 30-нд Наран 5 сарын 31-нд Онгон сумдад тус тус амжилттай тоглолоо. Нийт 501 том хүн, 1155 хүүхэд үзвэр үзсэн.

7. 6 сарын 1 буюу "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр уран бүтээлчид, ажилтнуудын 100 гаран хүүхдүүдэд "Гэгээн муза-11 наадам"-ын шилдэг бүтээл "Муурын байшин" мюзиклээ үнэ төлбөргүй үзүүллээ.

8. Хүүхэд багачуудад урлагийн боловсрол олгох, ахлах ангийн сурагчдад зориулсан шинэ бүтээл МУСТА У.Эрдэнэбаярын найруулга "Ромео үхэх ёсгүй" хүүхдийн оролцоот жүжгийг амжилттай тоглосон. Нийт 140 хүүхэд болон том хүнд үзүүлсэн.

9. Ардын хувьсгалын 103, Сүхбаатар аймаг байгуулагдсаны 82 жилийн ойн баяр наадмыг “Жаахан шарга” театрын Ерөнхий найруулагч МУСТА У.Эрдэнэбаярын найруулгаар "Оюуны галаа бадраа" нэрийн дор төв цэнгэлдэх хүрээлэнд 2024 оны 07 сарын 9-10-нд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, уран бүтээлд 50 уран бүтээлч, 82 хүүхэд оролцлоо.

10. Ардын хувьсгалын 103, Сүхбаатар аймаг байгуулагдсаны 82 жилийн ойн баяраар наадамчин олондоо зориулж наадмын талбайд “Жаахан шарга” театрын дуучдын “Бахархал” тоглолтыг тоглосон.

11. Хүн төрөлхтний соёл иргэншлийн үндэс язгуур болсон нүүдлийн соёлыг дэлхий нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль 8 сарын 16-18-ны хооронд болсон. Манай театраас нийт 20 уран бүтээлчид сумдын ардын авьяастангудтай оролцсон.

12. Тус театрын дуучин А.Баярхүү 10 сард анхны бие даасан уран бүтээлийн тайлан тоглолтоо хийхээр бэлтгэл ажил явагдаж байна.

13. Аймгийн 6 суманд урлагийн бригад 9 сард гарахаар төлөвлөгдсөн ч орон нутгийн ИТХ-ын сонгууль, бусад цаг үеийн арга хэмжээнүүдтэй холбоотойгоор хойшилж 10 сарын 15-20-ны хооронд явахаар төлөвлөөд байна.

14.

2.2 Төлөвлөгөөт бус уран бүтээл

1. Дорнод аймгийн Хөгжимт Драмын Театр “Гэгээн муза-16” наадмын шагналт Нүдтэй наран тамга хөгжимт драмын жүжиг мөн "Гэгээн муза-15" наадмын Гранпри шагналт "Мангасуудын хаан" хүүхдийн зөгнөлт жүжиг 2 дугаар сарын 14,15-нд амжилттай тоглосон.

2. Сүхбаатар аймгийн "Боловсрол өргөө" нэгдсэн дотуур байрын сурагчид "Малчдын хүүхдүүд дуулж байна" малчдад туслах хандивын тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Багш, сурагчдад баяр хүргэе. Уг тоглолтыг Жаахан шарга театрын УСУ, найруулагч З.Далай найруулж, заал танхимаар дэмжиж хамтран ажиллалаа.

3. Хөгжимчин Э.Сэвжидмаа “АЯС” хөгжмийн VIP цэнгүүн 3 сарын 2нд Улаанбаатар хотод Corsendonk Restaurant, Lounge & Karaoke-д амжилттай зохион байгуулсан.

4. Сүхбаатар аймгаас СУИС-д суралцаж байгаа Э.Ялгуунтөгс, Б.Энхтөгөлдөр, Э.Мөнхзолбоо нарын "Эгшигт аялгуу" хамтарсан тоглолтыг 4 сарын 27ны өдөр манай театрт амжилттай тоглосон. Заал болон техник хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.

5. Говьсүмбэр аймгийн Ц.Цэнджав даргатай Дуу, бүжгийн “Боржигин чуулга” шилдэг уран бүтээлүүд болох “Эрэлхэг эльф маранта” хүүхдийн жүжиг, “Сэцэн чин ван” түүхэн жүжиг, “Хөх тэнгэрийн нүүдэлчид” концертоо 2 өдөр амжилттай зохион байгуулсан.

6. “Найрсаг Баруун-Урт – ТЕАТР” өдөрлөгийг уламжлал ёсоор 4 дэх жилдээ Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран 9 сарын 11-13-ны хооронд зохион байгуулж 13-ны өдөр Сүхбаатарын талбайд бүрэн хэмжээний тоглолтыг иргэдэд үнэ төлбөргүй толилуллаа. Өдөрлөгийн нээлтийг театрын тайзнаа лектор Г.Наранбаатарын “Тогтвортой гэр бүлийн харилцаа тогтвортой жил амьдралын үндэс” лекцийг иргэдэд зохион байгууллаа. Хамрагдагсад: 400 иргэн.

7. Соёл урлагийн ажилтны 31 дэх өдөрт зориулсан “Соёлын орон зай” өдөрлөгийг 9 сарын 14-15-нд Аймгийн СУЗГ, соёлын байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Үүнд:

- 9 сарын 14-нд Соёлын ажилтны баярын хүндэтгэлийн нээлт, хурлын арга хэмжээг өөрийн тайзнаа хамтран зохион байгуулж “Сонгодог аяз” түүвэр концертыг МУК-ын концертмейстер багш Д.Отгонжаргалыг урилгаар авчиран аймгийн соёлын салбарын нийт ажилтан албан хаагчдад толилууллаа.
- Театрын хойд талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж хуучны болон орчин үеийн хөгжим болоод хувцас хэрэглүүрийг дэлгэн үзүүлэн гаргаж, “Жаахан шарга” клубийн гишүүн дуучин МУСТА А.Идэрзаяа, охины хамт монгол бичгийн бийрийн уран бичвэрээр ирсэн үзэгчдэд бичиж дурсгалаа. Энэ үеэр аймгийн Сурагчдын зөвлөлтэй хамтран “Open Mic” нээлттэй микрофоныг аялуулсан.
- Соёлын ажилтнуудын 4 төрөлт “Спортын нөхөрсөг” тэмцээнд театрын 2 баг оролцож 2-р баг шилжин явах цомыг авсан.
- Аймгийн СУЗГ-аас зохион байгуулсан “Уран бичлэг”-ийн уралдаанд Үзгийн хичээнгүй бичгийн төрөлд хамт олноороо 1-р байрт, Бийрийн уран бичлэгийн төрөлд 1, 2-р байрт тус тус шалгарсан.

8. Монголын хараагүйчүүдийн холбооны гишүүн С.Чинбатын “Сэтгэлийн гэгээ” тоглолтыг үнэ төлбөргүй зохион байгуулж, шум, гэрэл техник тайз хангаж, 298 үзэгч хамрагдсан.

Бусад газарт зохион байгуулсан арга хэмжээ:

- “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээ,
- “1000 ээжийн баяр” арга хэмжээ “Спорт цогцолбор”-т нээлт, хаалт, оройн хүлээн авалт,
- “Олимпын медалтныг угтах” ёслолын арга хэмжээ.

2.3 Олон улс, улс, бүст зохион байгуулагдсан наадам, фестиваль, уралдаан, түүнд оролцсон байдал

- Жаахан шаргын нутаг-2024 үндэсний бичгийн уралдааны “Үзгийн хичээнгүй бичиг”-ийн төрөлд 3-р байр эзэлсэн.
- Аймгийн Нийтийн номын сангаас зохион байгуулсан “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээний хүрээнд “Монгол бичгийн аварга уншигч-3” уралдаанд Удирдлага төлөвлөлтийн нэгжийн дарга, Хүний нөөцийн ажилтан Б.Тэмүүлэн тэргүүн байр эзэлсэн.

- Хөгжимчин Э.Сэвжидмаа нь Соёлын яам, Нийслэлийн Соёл урлагийн газар, СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулиас хамтран зохион байгуулсан үндэсний хөгжимчдийн “Уламжлалт арга барилаар хөгжимдөх” улсын анхдугаар уралдаанд 1-р шатны шалгаруулалтанд цахим хэлбэрээр 120 хөгжимчдөөс 2-р шатандаа 71 хөгжимчин шалгарч Улаанбаатар хотод СУИС-ын оюутан театрт 2 шат нь болж амжилттай оролцлоо.
- "Илүүдэл жингүй - Эртэч Сүхбаатарчууд" аяны хүрээд уламжлалт спортын наадмаа нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, дархлаагаа дэмжих, чөлөөт цагийн зөв өнгөрүүлэх, хамт олны эв нэгдэл эрч хүчийг хөглөх зорилгоор волейбол, 3х3 сагсан бөмбөг, дартс, хөгжөөнт буухиа, ширээний теннис, шугаман бүжиг нийт 6 төрлөөр 6 багийн 74 албан хаагч 2 өдөр өрсөлдөж амжилттай зохион байгуулагдсан.
- 8 сарын 16-18-ны хооронд зохион байгуулагдаж Нүүдэлчин дэлхийн соёлын олон улсын фестивалд Жаахан шарга театрын 20 уран бүтээлчид болон нутгийн өвлөн уламжлагч нар оролцож Дарьгангын уламжлалт соёлын өвийг сурталчилсан.

3.1 Сургалт

Мэргэшүүлэх сургалт /Их, дээд сургуульд гэрээгээр болон бие даан өөрийгөө хөгжүүлэх сургалт/

- Драм ангид мастер класс сургалтыг найруулагч, жүжигчин МУСТА Д.Бямбацогт 5 хоногийн хугацаанд зохион байгуулсан.
- Дуу ангид “хоолойн нэгдсэн дасгал”, “ганцаарчилсан дасгал”, “Мэргэжлийн зөвлөгөө”, “Онолын мэдлэг олгох” сургалтыг МУ-ын Консерваторийн Хормейстер багш Д.Нандинцэцэг, Концертмейстер багш Д.Отгонжаргал нар 10 хоногийн сургалт зохион байгуудсан.
- Хөгжимчдийн “Ур чадварын шалгаруулалт”-ын бэлтгэл ажлыг хангах, гоцлолоор оролцох хөгжимчидтэй ганцаарчилсан бэлтгэл хийх ажлыг МУ-ын Консерваторийн ХУДС-ийн Концермейстер Г.Уугандэлгэр 10 хоногийн сургалтыг зохион байгуулсан.
- Бүжигчдийн Ардын бүжгийн тайзны дасгал, эвлүүлэг, этюдийн нэгдсэн дасгалыг 5 хоногийн хугацаатай МУ-ын Консерватори, БЦМС, Ардын бүжгийн тэнхимийн эрхлэгч А.Хосбаяр багш зохион байгуулсан.
- Цагдаагийн газартай хамтран гэр бүл хүчирхийлэлийн эсрэг сургалт авсан.
- Угийн бичгийн сургалт сургагч багш Б.Гансүхээр ажилтнууддаа сургалт авсан.

Хүний нөөцийн төлөвлөлт /ирээдүйн мэргэжилтэн бэлтгэх сургалт/

- СУИС-ийн Уртын дуучны бакалаврын ангид 1 эмэгтэй уран бүтээлчийг бэлтгэн сургаж энэ жил төгссөн.

Хүүхэд багачуудын урлагийн авьяас чадварыг нээх, хөгжүүлэх, тэдэнд соёл урлаг, гоо зүйн мэдлэг олгох, ардын урлагаас суралцуулж, өвлөн уламжлуулах зорилгоор тус театрын уран бүтээлчид хүүхэд, залууст тогтмол төлбөртэй болон төлбөргүй сургалтыг зохион байгуулж байна. Үүнд:

- Хөгжимчин морин хуурч Б.Тэгшжаргал – 15 хүүхдэд морин хуур хөгжим зааж сургаж байна.
- Хөгжимчин Б.Алтантуул - Нийт 8 сурагчид төгөлдөр хуур хөгжмийн анхан шатны сургалтыг хичээллүүлж байна.
- Бүжигчин Б.Сайхантуяа – “Нарны хүүхдүүд” клубийн бүжгийн дугуйланд 30 хүүхэд, дууны дугуйланд 12 хүүхэд хамрагдаж байна.
- Зураач С.Гантөгс – Ganaa's Art зургийн дугуйланд 5 хүүхэд суралцаж байна.
- Уртын дуучин О.Бүрэндэлгэр – 1 хүүхдэд уртын болон ардын дуу дуулах арга барилын талаар сургалт орж байна.

Урлагийн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд театрын Захиргааны зөвлөлийн 9 сарын 19-ний хурлаар ирэх 10 сард Хөгжим анги, 11 сард Дуу анги, 12 сард Драм ангийг иргэдэд чиглэсэн урлагийн боловсролын арга хэмжээ, тоглолтыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохион байгуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллахыг үүрэг болгов.

ДӨРӨВ: СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, ГАДААД ДОТООД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1 Соёлын бүтээлч үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт

✓ Жаахан шарга театрын бүтээл АБТА Т.Жамъяансүрэнгийн зохиол МУСТА Д.Болортуяагийн найруулга "Тэрх нуурын дэгдээхэй" хүүхдийн оролцоот жүжгийг Наран сумын соёлын төвд ашиглах богино хугацааны франчайзингийн гэрээ байгуулсан.

✓ Ажилчдын ажиллах нөхцлөөр хангах зорилгоор мэргэжлийн 4 багшид сүүлийн үеийн TABLET авч өгсөн.

✓

4.2 Дотоодын байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагаа

- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 100 жилийн ойн нээлт хаалтын арга хэмжээг зохион байгуулахаар Сүхбаатар сумын 100 жилийн ой зохион байгуулах комисстой гэрээ байгуулсан. Ойн арга хэмжээ 7 сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулсан.

5. БУСАД

- Байгууллагын өөрийн хуваарьт талбайд 1 дүгээр сард “Бүх нийтийн цас цэвэрлэгээ”-ний ажилд эхний хагас жилийн байдлаар нийт 7 удаа , Баруун-Урт сумын Засаг даргын захирамжийн дагуу “Эрдэнэ Шарга “ дэлгүүрээс ЦГ-ын зүүн хойд хашааны булан хүртэлх хуваарьт талбайн цасыг 1 удаа тус тус цэвэрлэсэн. Байгууллагын гаднах хуваарьт талбайд их цэвэрлэгээг 5 удаа хийгдээд байна.

- Аймгийн Бүх нийтийн цэвэрлэгээ аяны хүрээнд баруун голыг дагасан талбайг цэвэрлэж голын эрэг дагуу байгаа хогийг түүсэн.

- Хувцасны өрөөнд малгайны хадгалалт хамгаалтыг сайжируулах зорилгоор шинээр малгайн тавиур хийсэн. Үүнд 100,0 мянган төгрөгийн зардал гарсан.

- Хөгжим ангидаа ажлын байрны таатай орчин бүрдүүлэх зорилгоор нот , дэвтэр хийх хэвтэй тавилга хийсэн. Тавилга хийх зардал нийт 1600,0 мянган төгрөг зарцуулсан.

- Тэр бум мод аяны хүрээнд Агч мод 50 ширхэг Хайлаас 250 ширхэг мод тарьж нийт мод тарих зардал 880,0 мянган төгрөг болсон.

ТАЙЛАН БИЧСЭН:

МЕНЕЖЕР

А.БОЛД-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДАРГА

Х.ЭРДЭНЭДЭЛГЭР

2024 оны 09 сарын 24.